

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2023/166/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баян-Өлгий аймаг

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Ж.Назгүл

Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ГАЗРЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА
Н.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2023.02.08 № 31

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Буянт сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/10 дугаар захирамжаар тус газарт "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд мод тарьж, ногоон байгууламж байгуулах зориулалтаар 40 жилийн хугацаатай олгосон 2 га газрын гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээг аваагүй байна.

Аудитын гол асуудал

"Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд 2 га газарт хашаа татаж, худаг гаргаж 950 мод тарьсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>48,607,036.90</u>	<u>48,251,160.25</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	48,607,036.90	48,251,160.25
351	Түүхий эд материал	19,767,213.00	21,029,433.00
35110	Тусгай зориулалттай материал	17,837,573.00	18,806,973.00
35130	Эм боох материал	1,929,640.00	2,222,460.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	4,098,836.25
354	Хангамжийн материал	28,839,823.90	23,122,891.00
35410	Бичиг хэргийн материал	175,200.00	-
35420	Аж ахуйн материал	26,196,808.00	19,107,860.00
35430	Сэлбэг хэрэгсэл	718,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	-	-
35450	Барилгын засварын материал	1,297,100.00	760,000.00
35460	Хүнсний материал	452,715.90	3,255,031.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>156,001,820.78</u>	<u>194,841,147.29</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	156,001,820.78	194,841,147.29
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	113,293,820.78	152,133,147.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,683,256.70	21,683,256.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4,189,412.16)	(5,585,882.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	153,550,354.27	149,235,891.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(114,211,465.92)	(85,733,333.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,182,208.00	100,624,343.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(41,015,411.63)	(53,747,432.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,962,530.00	35,062,952.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,827,038.48)	(13,565,446.48)
39209	Зам, гүүрийн байгууламж	-	-
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4,158,800.00	4,158,800.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,238,000.00	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,238,000.00)	-
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	-	-
393	Биет бус хөрөнгө	42,708,000.00	42,708,000.00
39301	Програм хангамж	6,417,692.31	6,417,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,417,692.31)	(6,417,692.31)
39303	Бусад биет бус хөрөнгө	42,708,000.00	42,708,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>204,608,857.68</u>	<u>243,092,307.54</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>204,608,857.68</u>	<u>243,092,307.54</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	204,608,857.68	243,092,307.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	126,241,246.90	126,241,246.90
51101	Өмч: - төрийн	126,241,246.90	126,241,246.90
512	Хуримтлагдсан үр дүн	59,361,777.65	97,845,227.51
51210	Өмнөх үеийн үр дүн	59,361,777.65	59,361,777.65
51220	Тайлант үеийн үр дүн	-	38,483,449.86
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,005,833.13	19,005,833.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>204,608,857.68</u>	<u>243,092,307.54</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	630,514,065.00	715,766,236.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,493,465.00	61,226,336.26
120	Нийтлэг татварын бус орлого	22,493,465.00	61,226,336.26
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	19,805,465.00	60,726,336.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,655,465.00	60,726,336.26
120009	Бусад орлого	2,688,000.00	500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	608,020,600.00	654,539,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	594,520,600.00	631,539,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	594,520,600.00	631,539,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,500,000.00	23,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,500,000.00	4,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	18,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	628,847,199.60	677,282,786.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	628,847,199.60	677,282,786.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	622,815,620.14	672,608,812.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	465,156,000.00	478,580,038.39
210101	Үндсэн цалин	288,338,400.00	303,787,200.00
210102	Нэмэгдэл	174,045,600.00	165,638,113.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,188,000.00	1,094,138.39
210104	Урамшуулал	1,584,000.00	8,060,586.95
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,175,920.54	9,527,787.21
210205	Эрүүл мэндийн даатгал	10,175,920.54	9,527,787.21
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,710,200.00	50,734,700.00

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	9,701,400.00	8,611,100.00
210302	Түлш, халаалт	28,554,200.00	32,254,000.00
210303	Цэвэр, бохир ус	6,954,600.00	6,369,600.00
210304	Байрны түрээс	3,500,000.00	3,500,000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	28,298,732.00	41,176,083.01
210401	Бичиг хэрэг	1,632,850.00	1,846,500.00
210402	Тээвэр, шатахуун	14,930,852.00	26,176,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,279,800.00	3,456,900.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	89,600.00	73,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,093,650.00	1,529,895.01
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
210408	Бараа материал акталсны зардал	6,271,980.00	8,093,288.00
2105	Нормативт зардал	30,394,322.36	32,857,264.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	430,840.00	891,480.00
210502	Хоол, хүнс	29,963,482.36	31,965,784.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,445,140.00	21,159,850.00
210604	Урсгал засвар	6,445,140.00	21,159,850.00
2107	Томилолт, зочны зардал	1,039,000.00	744,000.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	1,039,000.00	744,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,940,000.00	3,382,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,224,000.00	2,101,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,900.00	222,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	111,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	840,500.00
210807	Газрын төлбөр	128,100.00	107,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,656,305.24	34,446,388.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,479,400.00	10,290,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	243,900.00	150,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,933,005.24	24,005,788.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,031,579.46	4,673,974.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	159,600.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	159,600.00	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,754,000.00	3,814,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,754,000.00	3,814,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	117,979.46	859,974.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,979.46	859,974.40

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,666,865.40</u>	<u>38,483,449.86</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,666,865.40</u>	<u>38,483,449.86</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>610,858,600.00</u>	<u>655,039,900.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,838,000.00	500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,838,000.00	500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	150,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000.00	
120009	Бусад орлого	2,688,000.00	500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	608,020,600.00	654,539,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	594,520,600.00	631,539,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	594,520,600.00	631,539,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,500,000.00	23,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,500,000.00	4,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		18,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>603,218,800.00</u>	<u>645,652,200.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	603,218,800.00	645,652,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	598,531,220.54	641,478,225.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	466,500,000.00	479,080,038.39
210101	Үндсэн цалин	289,682,400.00	304,287,200.00
210102	Нэмэгдэл	174,045,600.00	165,638,113.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,188,000.00	1,094,138.39
210104	Урамшуулал	1,584,000.00	8,060,586.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,175,920.54	9,527,787.21
210205	Эрүүл мэндийн даатгал	10,175,920.54	9,527,787.21
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,532,200.00	50,734,700.00
210301	Гэрэл, цахилгаан	9,701,400.00	8,611,100.00
210302	Түлш, халаалт	28,376,200.00	32,254,000.00
210303	Цэвэр, бохир ус	6,954,600.00	6,369,600.00
210304	Байрны түрээс	3,500,000.00	3,500,000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	18,792,400.00	31,769,700.00
210401	Бичиг хэрэг	972,300.00	1,563,300.00
210402	Тээвэр, шатахуун	13,827,800.00	26,176,300.00

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,279,800.00	3,456,900.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	89,600.00	73,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	622,900.00	500,000.00
2105	Нормативт зардал	26,567,100.00	35,639,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	544,000.00	871,800.00
210502	Хоол, хүнс	26,023,100.00	34,768,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,261,300.00	9,236,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,296,200.00	2,444,500.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	4,965,100.00	6,792,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,039,000.00	744,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,039,000.00	744,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,940,000.00	3,518,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,224,000.00	2,237,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,900.00	222,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	111,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	840,500.00
210807	Газрын төлбөр	128,100.00	107,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,723,300.00	21,226,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,479,400.00	21,028,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	243,900.00	198,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,687,579.46	4,173,974.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	159,600.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	159,600.00	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,410,000.00	3,314,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,410,000.00	3,314,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	117,979.46	859,974.40
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,979.46	859,974.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,639,800.00</u>	<u>9,387,700.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,639,800.00	9,387,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,639,800.00	9,387,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,639,800.00	9,387,700.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	7,639,800.00	9,387,700.00

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,639,800.00)</u>	<u>(9,387,700.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	126,241,246.90				126,241,246.90
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,241,246.90	0.00	0.00	0.00	126,241,246.90
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			83,044,053.00		83,044,053.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,241,246.90	0.00	83,044,053.00	0.00	209,285,299.90
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	126,241,246.90	0.00	57,694,912.25	0.00	183,936,159.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		21,721,945.13	59,361,776.65		81,083,721.78
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,241,246.90	19,005,833.13	59,361,777.65	0.00	204,608,857.68
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			38,483,449.86		38,483,449.86
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,241,246.90	19,005,833.13	97,845,227.51	0.00	243,092,307.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	631,539,900.00	630,679,925.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	631,539,900.00	630,679,925.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	628,725,900.00	627,865,925.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	479,173,900.00	479,080,038.39
210101	Үндсэн цалин	304,287,200.00	304,287,200.00
210102	Нэмэгдэл	172,114,700.00	165,638,113.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,188,000.00	1,094,138.39
210104	Урамшуулал	1,584,000.00	8,060,586.95
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,293,900.00	9,527,787.21
210205	Эрүүл мэндийн даатгал	10,293,900.00	9,527,787.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,234,700.00	47,234,700.00
210301	Гэрэл, цахилгаан	8,611,100.00	8,611,100.00
210302	Түлш, халаалт	32,254,000.00	32,254,000.00
210303	Цэвэр, бохир ус	6,369,600.00	6,369,600.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	31,769,700.00	31,769,700.00
210401	Бичиг хэрэг	1,563,300.00	1,563,300.00
210402	Тээвэр, шатахуун	26,176,300.00	26,176,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,456,900.00	3,456,900.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	73,200.00	73,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	500,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	35,639,900.00	35,639,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	871,800.00	871,800.00
210502	Хоол, хүнс	34,768,100.00	34,768,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,624,200.00	18,624,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,832,200.00	11,832,200.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	6,792,000.00	6,792,000.00
2107	Томилолт, зочны зардал	744,000.00	744,000.00

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	744,000.00	744,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,518,900.00	3,518,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,237,500.00	2,237,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	222,200.00	222,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	111,000.00	111,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	840,500.00	840,500.00
210807	Газрын төлбөр	107,700.00	107,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,726,700.00	1,726,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,528,100.00	1,528,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	198,600.00	198,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,814,000.00	2,814,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,814,000.00	2,814,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,814,000.00	2,814,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	631,539,900.00	630,679,925.60
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	631,539,900.00	630,679,925.60
131001	Улсын төсвөөс санхүүжих	631,539,900.00	630,679,925.60
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	36.00	36.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	35.00	35.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	36.00	36.00
650001	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)		
650002	Терийн тусгай албан хаагч (ТТ)	36.00	36.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,000,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,500,000.00

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210304	Байрны түрээс	3,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоодог байгууллага юм.

Тус байгууллагын эрхэм зорилго нь байгууллагын үйл ажиллагааны дотоод зохион байгуулалт, ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг журамлахын зэрэгцээ албан хаагчдын эрх үүргийг тодорхойлох, нийгмийн баталгааг хангах ажиллах хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, албаны сахилга бат дотоод дэг журмыг сахиулах эрэгтэй холбогдон үүссэн хөдөлмөрийн харилцааг зохицуулахыг оршино.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 2022 оныг “Алба хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн, ногоон төгөл, хүний хөгжлийг дэмжих” жил болгон зорилтыг дэвшүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хууль журмыг ашигладаг байна. Үүнд:

- ❖ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
- ❖ Төрийн албаны тухай хууль
- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ❖ Шилэн дансны тухай хууль

- ❖ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ❖ Татварын тухай хууль гэх мэт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ. Тус байгууллагад дотоод аудитын нэгж ажилладаггүй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас дотоод аудитаас тайлант онд шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/134 тоот тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон түүний харьяа байгууллагуудын хэмжээнд мөрдөж ажилладаг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38.5 сая төгрөгөөр буюу 18.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	48,607.0	48,251.2	(355.8)
Үндсэн хөрөнгө	156,001.8	194,841.1	38,839.3
Нийт хөрөнгө	204,608.8	243,092.3	38,483.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	204,608.8	243,092.3	38,483.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	204,608.8	243,092.3	38,483.5

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос бараа материалын данс 0.3 сая төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгийн данс 38.8 сая төгрөгөөр, Засгийн газрын хувь оролцоо данс 38.5 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна. Оны эхэнд бараа материалын данс 48.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр нийт 87.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч 7.3 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй хүлээн авч, 87.1 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны А/273 дугаар тушаалаар 8.1 сая төгрөгийн материалыг акталж, оны эцэст 48.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. Аж ахуйн дансанд байсан 0.7 сая төгрөгийн тусгай зориулалтын материал, 4.1 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн, 0.06 сая төгрөгийн барилгын материалыг данс хооронд шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 336.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 9.4 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч 53.4 сая төгрөгийн дансны үнэтэй үндсэн хөрөнгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газраас шилжүүлэн авч, 35.6 сая төгрөгийн элэгдлээ бүрэн нөхсөн тээврийн хэрэгслийг 439 дүгээр хорих ангийн дансанд шилжүүлсэн байна.

Баян-Өлгий аймгийн Буянт сумын Засаг даргын захирамжаар Буянт сумын 4 дүгээр багт 2 га газарт “Тэрбум мод”-ны хөтөлбөрийн хүрээнд Шүүхийг шийдвэр гүйцэтгэх газрын төсвийн хөрөнгөөр 8.0 сая төгрөгийн хашаа татаж, 3.2 сая төгрөгийн худаг гаргаж 950 ш мод тарьжээ.

Тайлант хугацааны эцэст өр төлбөргүй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 243.1 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 38.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 815.0 сая, нийт зарлагыг 815.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 215.8 зардлыг сая төгрөгөөр бууруулж 599.2 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 32.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 631.5 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 631.5 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 630.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, жилийн эцэст 0.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 630.7 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 0.8 төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	620,273.6	619,416.7	(856.9)	99.9
2	80220-Холбооны суваг ашигласны хөлс	942.4	942.4	-	100.0
3	80229-Шийдвэр гүйцэтгэлийн үнэлгээ	7,509.9	7,509.9	-	100.0
4	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,814.0	2,814.0	-	100.0
	Дүн	631,539.9	630,683.0	(856.9)	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/82 дугаар захирамжаар Засаг даргын ангилагдаагүй нөөц хөрөнгөөс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын даргын байрны хөлсөнд 3.5 сая төгрөгийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газраас 18.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/81 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 628.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: унаа хоолны хөнгөлөлт, ЭМД-ын зардлыг 0.8 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа, зөрчил илэрч албан шаардлага өгсөн. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/85 дугаар тушаалаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “100 сая мод тарих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Шилдэг ногоон байгууламж, тохижилттой шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги” шалгаруулах 15.4 сая төгрөгийн шагналын сантай болзолт уралдааныг зохион байгуулсан байна.

Болзолт уралдааны хүрээнд тус газар дотооддоо “Эко-100” хоног уралдаан зарлаж идэвх зүтгэл гаргаж оролцсон алба хаагчдад газрын даргын 2022 оны Б/16 дугаар тушаалаар үндсэн цалингийн 10-15 хувиар 1.2 сая төгрөгийн мөнгөн шагнал олгосон нь хууль, журамд нийцээгүй байна.

2. Тайлант онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 22.7 сая төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 6.4 сая төгрөгийн автомашины сэлбэг хэрэгслийг орлогод авч, 8.7 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг зарцуулжээ. Үүнээс 2022 оны 3 дугаар сард 3.2 сая төгрөгөөр хувь хүмүүсээс хуучин мотор худалдан авч Приус-20 маркийн машины моторыг сольсон боловч моторт нь эвдрэл гарч 2022 оны 11 дүгээр сард дахин шинээр мотор тавьж үр ашиггүй зардал гаргасан байна.

Аудитад ирүүлсэн санхүүгийн баримтад техникийн комиссын акт, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, хөрөнгө устгалын комиссын шийдвэр, зурагжуулсан нотлох баримтыг ирүүлээгүй, аудитын явцад материалыг бүрдүүлж өгсөн болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 6 дугаар зүйлийн 6.4.8, 6.8.1 дэх заалтыг зөрчиж 7.7 сая төгрөгийн мөнгө зарцуулсан тушаал шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна. Мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75 хувьтай байна

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой залруулга хийх алдаа илрээгүй.

Аудитаар нийт 23.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 18.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Байгууллагынхаа үндсэн чиг үүрэгт хамааралгүй уралдаан зарлаж идэвх гаргасан алба хаагчдад газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар үндсэн цалингийн 10-15 хувийн буюу 1.2 сая төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Байгууллагын 2 жолоочийн хувийн дансанд 3.2 сая төгрөгийг шилжүүлж, хувь хүмүүсээс хуучин мотор худалдан авч, 2022 оны 3 дугаар сард 8331БӨА дугаартай, Приус-20 маркийн машины моторыг сольсон боловч мотор нь хэдхэн сарын дараа эвдэрсний улмаас 2022 оны 11 дүгээр сард дахиж шинээр мотор тавьж үр ашиггүй зардал гаргасан зөрчилд албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Буянт сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/10 тоот захирамжаар тус сумын 4 дүгээр багт 2 га газрыг Шүүхийг шийдвэр гүйцэтгэх газарт эзэмшүүлэх зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэсний дагуу “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд 950 ш чацарганын суулгац тарихад төсвийн хөрөнгөөр 8.0 сая төгрөгийн өргөст торон хашаа, худаг гаргахад гарсан 3.2 сая төгрөгийн, нийт 11.2 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж, зарлага гаргасан байна.

Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2.Өгсөн зөвлөмж:

Төсвийн хөрөнгөөр бий болсон 11.2 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгах арга хэмжээ авч ажиллах.

2. Байгууллагын эзэмшлийн газартай холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Буянт сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/10 дугаар захирамжаар тус газарт “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд мод тарьж, ногоон байгууламж байгуулах зориулалтаар 40 жилийн хугацаатай олгосон 2 га газрын гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээг аваагүй байна.

Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д "Энэ хуулийн 33.1-д заасан газар эзэмшүүлэх тухай шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, улсын бүртгэлд бүртгэнэ", 34.8-д "Газар эзэмших гэрээ нь эрхийн гэрчилгээний хамт хүчин төгөлдөр байх бөгөөд гэрээний биелэлтийг талууд жил бүр дүгнэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Дээрх зориулалтаар авсан 2 га газрыг хууль, журмын дагуу гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээг авч холбогдох журмын дагуу үнэлж, данс бүртгэлд тусгах.

3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 7.7 сая төгрөгийн мөнгө зарцуулсан тушаал шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг зөрчсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээ хугацаандаа бүрэн байршуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр хийгдсэн 11.2 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын зардлаар бүртгэж, данс бүртгэлээс хассан	1	11170.0									1	11170.0
Дүн	1	11170.0									1	11170.0

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 5 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна	1	7740.4					1	7740.4
Дүн	1	7740.4					1	7740.4
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Мөнгөн шагнал олгох журам зөрчиж байгууллагын алба хаагчдад шагнал олгож үргүй зардал гаргасан			1	1185.5				
Жолоочийн хувийн дансанд мотор болон сэлбэгийн мөнгө шилжүүлж тайлант онд 2 мотор сольж үргүй зардал гаргасан					1	3180.0		
Байгууллагын эзэмшил газарт эзэмших эрхийн гэрчилгээ авч, данс бүртгэлд тусгаагүй байна							1	
Дүн	3	12105.5	1	1185.5	1	3180.0	1	7740.4
Нийт дүн	5	23275.9	1	1185.5	1	3180.0	3	18910.4